

# САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2007 оны 10 дугаар  
сарын 30-ны өдөр

Дугаар 135

Улаанбаатар хот

Даатгалын компани болон даатгалын мэргэжлийн  
оролцогчоос төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний  
хөлсний хэмжээг тогтоох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.5, Даатгалын тухай хуулийн 14.2.17, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 6.2.5, Санхүүгийн зохицуулах хорооны дүрмийн 5.3-д заасныг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Даатгалын компани болон даатгалын мэргэжлийн оролцогчоос төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Хорооны 2006 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн 33 дугаар тогтоолын Даатгалын компани болон даатгалын мэргэжлийн оролцогч байгууллагын зохицуулалтын үйлчилгээний төрөл, хэмжээг тогтоосон 2 дугаар хавсралт болон Хорооны 2007 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 124 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, нийтэд сурталчлан ажиллахыг Даатгалын газар (С.Ганболд)-г даалгасугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН

ДААТГАЛЫН КОМПАНИ БОЛОН ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН  
ОРОЛЦОГЧООС ТӨВЛӨРҮҮЛЭХ ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ХӨЛСНИЙ ХЭМЖЭЭ

Нэг. Жил бүр төвлөрүүлэх

Даатгалын компани болон даатгалын мэргэжлийн оролцогчоос төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг тухайн оны 3 дугаар сарын 1-ний дотор Хадгаламж банкин дахь Хорооны 1700041422 тоот дансанд төвлөрүүлнэ.

1.1. Ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч даатгалын компаниас төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ:

д/д	Даатгалын хэлбэр	Энгийн тусгай зөвшөөрөл (Даатгалын хэлбэр тус бүрээр дүрмийн сангаас доорх хувиар тооцно)	Нэмэлт тусгай зөвшөөрөл (мянган төгрөгөөр)
1.1.1.	Гэнэтийн ослын	0.050	
1.1.2.	Эрүүл мэндийн (арилжааны)	0.050	
1.1.3.	Хөдөлмөрийн чадвар алдалтын	0.080	
1.2.1.	Хөрөнгийн	0.100	
1.2.2.	Байшин барилгын	0.200	
1.2.3.	Орон сууцны	0.010	
1.2.4.	Бараа материалын	0.100	
1.2.5.	Тоног төхөөрөмжийн	0.150	
1.2.6.	Авто тээврийн хэрэгслийн	0.030	
1.2.7.	Ачааны	0.050	
1.2.8.	Иргэний агаарын хөлгийн		500.0
1.2.9.	Газрын тосны		500.0
1.2.10.	Газрын тосны бүтээгдэхүүний	0.100	
1.2.11.	Ашигт малтмал, уул уурхайн	0.100	
1.2.12.	Таримлын		300.0
1.2.13.	Мал амьтдын	0.020	
1.2.14.	Баримт бичгийн	0.025	
1.2.15.	Илгээмж шуудангийн	0.020	
1.3.1.	Жолоочийн хариуцлагын	0.030	
1.3.2.	Бүх төрлийн мэргэжлийн хариуцлагын	0.100	
1.3.3.	Иргэдийн	0.025	
1.3.4.	Барилга угсралтын	0.150	
1.3.5.	Орон сууцны хариуцлагын	0.025	
1.3.6.	Олон нийтийн өмнө хүлээх хариуцлагын	0.100	
1.3.7.	Байгууллагын хариуцлагын	0.100	
1.3.8.	Өмчлөгч болон эзэмшигчийн хариуцлагын	0.100	

1.3.9.	Бүтээгдэхүүн, үйлчилгээний хариуцлагын (экспортлогч, импортлогч, үйлдвэрлэгч)	0.100	
1.3.10.	Тээвэрлэгчийн хариуцлагын	0.050	
1.3.11.	Агаарын хөлгийн их бие, түүнийг өмчлөгч болон эзэмшигчийн хариуцлагын		600.0
1.3.12.	Гэрээний хариуцлагын	0.025	
1.3.13.	Хуулийн хариуцлагын	0.025	
1.3.14.	Ажил олгогчийн хариуцлагын	0.100	
1.3.15.	Ажиллагсдын хариуцлагын	0.100	
1.3.16	Монгол Улсын нутагт түр хугацаагаар орох болон дамжин өнгөрч буй авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын	0.020	
1.4.1.	Бизнес тасалдлын	0.025	
1.4.2.	Зээлийн эрсдэлийн	0.025	
1.4.3.	Хадгаламжийн	0.025	
1.4.4.	Бэлэн мөнгө, үнэт цаасны	0.100	
1.4.5.	Чин шударгын баталгааны (Fidelity guarantee insurance)	0.025	
1.4.6.	Гүйцэтгэлийн баталгааны (Performance insurance)	0.030	
1.5.1.	Гадагш өгөх давхар даатгал (outward)	0.025	
1.5.2.	Гаднаас авах давхар даатгал (inward)	0.200	

Тайлбар: Урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч даатгалын компани, түүний салбар, гадаадын даатгагч Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газраа нээж түүгээр дамжуулан даатгалын үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдуулан төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг Хорооны тогтоолоор шийдвэрлэнэ.

1.2. Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан даатгалын мэргэжлийн оролцогчоос төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ:

д/д	Зохицуулалтын үйлчилгээний төрөл	Төвлөрүүлэх хөлсний хэмжээ (мянган төгрөгөөр)
1	Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх 1.1. Улаанбаатар хотод 1.2. Улаанбаатар хотоос бусад орон нутагт	20.0 10.0
2	Даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх 2.1. Улаанбаатар хотод 2.2. Улаанбаатар хотоос бусад орон нутагт	300.0 150.0
3	Даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх 3.1. Улаанбаатар хотод 3.2. Улаанбаатар хотоос бусад орон нутагт	300.0 200.0

Тайлбар: Гадаадын даатгалын мэргэжлийн оролцогч Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газраа нээж түүгээр дамжуулан даатгалын үйл ажиллагаа эрхлэхтэй

холбогдуулан төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг Хорооны тогтоолоор шийдвэрлэнэ.

Хоёр. Тухай бүр төвлөрүүлэх

д/д	Зохицуулалтын үйлчилгээний төрөл	Төвлөрүүлэх хөлсний хэмжээ (мянган төгрөгөөр)
1	Салбар, төлөөлөгчийн газар байгуулах зөвшөөрөл 1.1. Улаанбаатар хотод 1.2. Улаанбаатар хотоос бусад орон нутагт	200.0 20.0
2	Төлөөлөгчийн газар байгуулах	100.0
3	Нэр өөрчлөх 3.1. Компанийн оноосон нэр 3.2. Салбарын нэр	2000.0 500.0
4	Даатгагч өөрийн мэдээллийг Хорооны архиваас хуулбарлан нөхөн авах	1.0 (нэг хуудас)
5	Үрэгдүүлж, гэмтээсэн гэрчилгээг нөхөн олгох	200.0
6	Хуулинд заасан бусад үйлчилгээ үзүүлэх	Хорооны тогтоолоор тухай бүрд шийдвэрлэнэ

Тайлбар: Улаанбаатар хотоос бусад орон нутагт байгуулагдсан боловч салбараа Улаанбаатар хотод нээн үйл ажиллагаа явуулж байгаа даатгалын компани болон даатгалын мэргэжлийн оролцогчийн хувьд зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг Улаанбаатар хотод байршилтай даатгалын компани болон даатгалын мэргэжлийн оролцогчийн жишгээр тогтооно.

Гадаадын даатгагч болон даатгалын гадаадын мэргэжлийн оролцогчид Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газраа байгуулах зөвшөөрөл олгоход төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг Хорооны тогтоолоор тухай бүрд шийдвэрлэнэ.